

МЭРГЭШИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- Хүлээн авах яаралтай тусламжийн их эмчээр резентурт Өсвөр үеийн их эмч Оюунцэцэг, Хөнгөвчлөх хими эмчилгээний 6 сарын курс Их эмч Б.Үүрцайх, Гемодиализын сувилагчаар мэргэшүүлэх курст Сувилагч Дугармаа, Сувилагч мэргэжлээр Туслах сувилагч Д.Нямдаваа, Мэс заслын боолтны сувилагчаар Сувилагч Отгончимэг, Гернтологийн төвд Настны эмгэг судлал чиглэлээр 6 сарын нарийн мэргэжил олгох Ахмадын их эмч Ч.Ганцэцэг, Сэтгэл засал судлал төрөлжсөн мэргэжил Их эмч Хоролсүрэн, Тархвар судлал судлалын 6-н сарын олгох курст Тархвар судлаач Цэндсүрэн, Хулан тус тус суралцаж байна.
- 2020 оны эхний хагас жилийн байдлаар ажил, мэргэжлийн давтан сургалтанд давхардсан тоогоор 23 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан байна. 2020 оны 02 дугаар сард эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдвээр 2 кредитийн сургалт зохион байгуулсан бөгөөд 110 хүн хамрагдсан.

ЦАЛИН ХӨЛС

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 382, 472 тоот тогтоолын дагуу нийт ажилчдын ажилласан жилийг тулган, шинэчилснээр 2020 оны 01 сарын 02-ны өдрөөс эхлэн нийт 45 ажилтны цалингын шатлалыг ахиулж, төрийн албанд ажилласан хугацааны цалингийн нэмэгдэл 160 ажилтанд олгосон бөгөөд ээлжийн амралтын хоногийг тогтоож ажилчдын цалинг 8% нэмэгдүүлсэн байна .

АЛБАН ХААГЧДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- Хан-Уул Эрүүл мэндийн төвийн 2020 оны 02 сард нийт ажилчдыг хоолойн арчидасын шинжилээнд хамруулж ажилчдын эмчийн үзлэгт хамруулав.

АЖЛЫН БАЙРНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ

- 2020 оны эхний хагас жилийн байдлаар эмч, эмнэлгийн ажилтны судалгааг авч нийт 130 хүн хамрагдсанаас ажилчдын ерөнхий сэтгэл ханамжийн судалгааны дүн 73% байна
Ерөнхий дүнгээр үндсэн 6 асуумжийн сайн буюу өссөн хувиар дүгнэдсэн байна.
 - Дэмжлэгт удирдлага
 - Хүний нөөцийн хөгжих боломж
 - Эмнэлгийн ёс зүй, үйлчилгээний соёл
 - Байгууллагын соёл зэрэг нь 45,5%- 80,15% болж өссөн дүнтэй байна.Эмч мэргэжилтний хэрэгцээний судлах зорилгоор ажиллагсадаас санал асуумж авч эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх, тэдгээрийн мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх талаар ямар чиглэлээр суралцах талаар судалгаа гарган ажиллаж байна.